

СҮХБААТАР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Сүхбаатар аймгийн Соёл, урлагийн газрын 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: СБА-2023/177/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn	Сүхбаатар аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор: М.Нарантуяа
Баруун-Урт	Утас: 99029193 Цахим хаяг: naranuyam@audit.gov.mn
2023 он	Аудитын менежер: Утас: 99035990 Цахим хаяг: davaag@audit.gov.mn
	Аудитор: Утас: 91009002 Цахим хаяг: altansukhe@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	3
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ.....	5
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА	9
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа	9
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин	9
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	9
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд.....	9
3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	10
4. АУДИТЫН ТАЙЛАН	11
4.1 Ерөнхий зүйл.....	11
4.2 Материаллаг байдал.....	11
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	11
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	11
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт.....	11
4.5 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	12
4.5.1 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн	12
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	12
5.1 Зөвлөмж.....	12
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ	13

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



СҮХБААТАР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

22000 Баруун-Урт сум, Сүхбаатар аймаг
Утас: 70518396, Факс: 70518396
E-mail: Sukhbaatar@audit.gov.mn

2023.02.25 № 83
танай _____-ны № _____-т

СҮХБААТАР АЙМГИЙН СОЁЛ,
УРЛАГИЙН ГАЗРЫН ДАРГА
Х.ЭРДЭНЭДЭЛГЭР ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Сүхбаатар аймгийн Соёл, урлагийн газрын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Сүхбаатар аймгийн Соёл, урлагийн газрын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Байгууллагын үйл ажиллагааны тасралтгүй байх зарчим, холбоотой талуудтай хийсэн ажил гүйлгээний анхаарал татсан асуудал болон санхүүгийн тайлангийн аудитын хойших үйл явдал, бусад асуудлын талаар тодорхойгүй байдал үүсээгүй болно.

Аудитын гол асуудал

Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд шалгуур үзүүлэлтийн суурь ба хүрэх түвшнийг тодорхойлохдоо үйл ажиллагааны статистик тоон мэдээллийг бага ашигласан, үндсэн хөрөнгийн шинжтэй хөрөнгийг бараа материалын дансанд бүртгэсэн, цахим дэлгүүрт байршсан зөөврийн болон суурин компьютерыг бусад этгээдээс худалдан авсан, тухайн жилд худалдан авах арван сая төгрөгөөс дээш өртөг бүхий барааны жагсаалтыг цахим дэлгүүрт байршуулах хүсэлтийг Төрийн худалдан авах ажиллагааны газарт хүргүүлээгүй, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулахтай холбоотой шийдвэрийг шилэн дансны цахим хуудаст мэдээлээгүй зэрэг нь УСНББОУС, Төрийн хэмнэлтийн тухай хууль, Шиилэн дансны тухай хууль, "Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулах, гүйцэтгэлийн зорилт, шалгуур үзүүлэлтийг тогтоох, тайлан гаргах журам"-тай нийцэхгүй байна.

D:/Bichig hereg/2023/A4 toot

Бусад асуудлын хэсэг

Батлагдсан төсвийн хүрээнд байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөгөөр 4 зорилтын хүрээнд 69 арга хэмжээ хэрэгжүүлэхээр төлөвлөж, гүйцэтгэлээр 85.6 хувийн биелэлтэй хэрэгжүүлсэн гэж тайлагнасан байна. Тайлант онд “Хөшөө, дурсгалыг засварлах, түүх соёлын үл хөдлөх дурсгалын тооллого”, Номын сангийн сангийн сан хөмрөгийн бүрдүүлэлт”, “Нүүдэлчин Монгол-2022”, “Нутгийн уран бүтээлч, урчуудын хамтарсан үзэсгэлэн”, “Хун хүүхдийн урлагийн наадам”, “Соёлын бүтээлч сар” зэрэг арга хэмжээг холбогдох байгууллагуудтай хамтран хэрэгжүүлж ажилласан байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



М.НАРАНТУЯА

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	19,403,900.00	11,870,431.00
33	АВЛАГА	15,000,000.00	-
33300	Татаас, санхүүжилтийн авлага	15,000,000.00	-
35	БАРАА МАТЕРИАЛ	4,403,900.00	11,870,431.00
354	Хангамжийн материал	4,403,900.00	11,870,431.00
35410	Бичиг хэргийн материал	120,000.00	305,500.00
35420	Аж ахуйн материал	1,594,000.00	1,155,000.00
35440	Түлш, шатах тослох материал	2,689,900.00	-
35450	Барилгын засварын материал	-	114,500.00
35470	Бусад хангамжийн материал	-	10,295,431.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	1,661,000.00	58,275,347.58
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,661,000.00	58,275,347.58
392	Биет хөрөнгө	1,661,000.00	56,975,347.58
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	1,661,000.00	41,760,998.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	-	-1,582,134.27
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	-	18,297,196.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	-	-1,500,712.15
393	Биет бус хөрөнгө	-	1,300,000.00
39301	Програм хангамж	-	1,500,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-	-200,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	21,064,900.00	70,145,778.58
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	21,064,900.00	70,145,778.58
51	Засгийн газрын хувь оролцоо	21,064,900.00	70,145,778.58
512	Хуримтлагдсан үр дүн	21,064,900.00	70,145,778.58
51210	Өмнөх үеийн үр дүн	-	21,064,900.00
51220	Тайлант үеийн үр дүн	21,064,900.00	49,080,878.58
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	21,064,900.00	70,145,778.58

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	33,031,555.00	315,743,801.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	-	11,321,701.00
120	Нийтлэг татварын бус орлого	-	11,321,701.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	-	11,321,701.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	-	11,321,701.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	33,031,555.00	304,422,100.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	15,000,000.00	212,844,400.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	15,000,000.00	212,844,400.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	18,031,555.00	91,577,700.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	-	32,427,700.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	18,031,555.00	18,000,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	41,150,000.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	11,966,655.00	266,662,922.42
21	УРСГАЛ ЗАРДАЛ	11,966,655.00	266,662,922.42
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	11,966,655.00	265,401,720.84
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	4,123,590.00	110,459,258.13
210101	Үндсэн цалин	4,123,590.00	74,629,875.93
210102	Нэмэгдэл	-	10,907,123.40
210103	Унаа хоолны хөнгөлөлт	-	15,496,000.00
210104	Урамшуулал	-	9,426,258.80
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	-	15,478,301.36
210201	Тэтгэврийн даатгал	-	11,000,791.79
210202	Тэтгэмжийн даатгал	-	1,119,447.44
210203	ҮОМШӨ-ний даатгал	-	895,557.90
210204	Ажилгүйдлийн даатгал	-	223,609.23
210205	Эрүүл мэндийн даатгал	-	2,238,895.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	-	5,658,687.39
210301	Гэрэл, цахилгаан	-	422,087.39
210302	Түлш, халаалт	-	4,263,600.00
210303	Цэвэр, бохир ус	-	973,000.00

2104	Хангамж, бараа материалын зардал	236,065.00	49,849,700.54
210401	Бичиг хэрэг	236,065.00	13,704,653.00
210402	Тээвэр, шатахуун	-	19,774,900.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	-	2,084,820.54
210404	Ном, хэвлэл	-	10,750,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	-	205,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	-	3,330,327.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	110,000.00	1,663,300.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	110,000.00	-
210604	Урсгал засвар	-	1,663,300.00
2107	Томилолт, зочны зардал	1,752,000.00	6,968,000.00
210702	Дотоод албан томилолт	1,752,000.00	6,968,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	5,745,000.00	42,069,900.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	5,430,000.00	42,069,900.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	315,000.00	-
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	-	33,254,573.42
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	-	29,971,727.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	-	3,282,846.42
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	-	1,261,201.58
2132	Бусад урсгал шилжүүлэг	-	386,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	-	386,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	-	875,201.58
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	875,201.58
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	21,064,900.00	49,080,878.58
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	21,064,900.00	49,080,878.58

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	33,031,555.00	319,422,100.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	33,031,555.00	319,422,100.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	15,000,000.00	212,844,400.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	15,000,000.00	212,844,400.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	18,031,555.00	106,577,700.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	-	32,427,700.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	18,031,555.00	18,000,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	56,150,000.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	31,370,555.00	270,765,302.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	31,370,555.00	270,765,302.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	16,370,555.00	269,504,100.42
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	4,123,590.00	110,459,258.13
210101	Үндсэн цалин	4,123,590.00	74,629,875.93
210102	Нэмэгдэл	-	10,907,123.40
210103	Унаа хоолны хөнгөлөлт	-	15,496,000.00
210104	Урамшуулал	-	9,426,258.80
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	-	15,478,301.36
210201	Тэтгэврийн даатгал	-	11,000,791.79
210202	Тэтгэмжийн даатгал	-	1,119,447.44
210203	ҮОМШӨ-ний даатгал	-	895,557.90
210204	Ажилгүйдлийн даатгал	-	223,609.23
210205	Эрүүл мэндийн даатгал	-	2,238,895.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	-	5,658,687.39
210301	Гэрэл, цахилгаан	-	422,087.39
210302	Түлш, халаалт	-	4,263,600.00
210303	Цэвэр, бохир ус	-	973,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	3,939,965.00	34,943,416.54
210401	Бичиг хэрэг	356,065.00	2,944,833.00
210402	Тээвэр, шатахуун	2,689,900.00	17,085,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	-	2,285,620.54
210404	Ном, хэвлэл	869,000.00	10,750,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	-	205,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	25,000.00	1,672,963.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	110,000.00	6,788,550.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	110,000.00	866,300.00
210602	Тавилга	-	3,922,800.00

210604	Урсгал засвар	-	1,999,450.00
2107	Томилолт, зочны зардал	1,752,000.00	6,968,000.00
210702	Дотоод албан томилолт	1,752,000.00	6,968,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	6,445,000.00	42,121,900.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	5,430,000.00	42,121,900.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,015,000.00	-
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	-	47,085,987.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	-	40,901,667.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	-	6,184,320.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	15,000,000.00	1,261,201.58
2132	Бусад урсгал шилжүүлэг	-	386,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	-	386,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	-	875,201.58
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	875,201.58
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	15,000,000.00	-
213405	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	15,000,000.00	-
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	16,661,000.00	48,656,798.00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	1,661,000.00	48,656,798.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	1,661,000.00	48,656,798.00
2200	Дотоод эх үүсвэрээр	1,661,000.00	48,656,798.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	1,661,000.00	48,656,798.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	-1,661,000.00	-48,656,798.00
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	-	-
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2020 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	0.00	0.00	0.00	0.00	0.00
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	0.00	0.00	0.00
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	0.00	0.00	0.00	0.00	0.00
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	0.00	0.00	0.00	0.00	0.00
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	0.00	0.00	0.00	0.00	0.00
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0.00	0.00	0.00	0.00	0.00
C07	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	21,064,900.00	0.00	21,064,900.00
C08	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	0.00	0.00	21,064,900.00	0.00	21,064,900.00
D01	2022 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	0.00	0.00	21,064,900.00	0.00	21,064,900.00
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	0.00	0.00	0.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	0.00	0.00	21,064,900.00	0.00	21,064,900.00
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	0.00	0.00	0.00	0.00	0.00
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	0.00	0.00	0.00	0.00	0.00
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0.00	0.00	0.00	0.00	0.00
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү					0.00
D08	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	49,080,878.58	0.00	49,080,878.58
D09	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	0.00	0.00	70,145,778.58	0.00	70,145,778.58

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

№	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	212,844,400.00	211,969,198.42
21	УРСГАЛ ЗАРДАЛ	212,844,400.00	211,969,198.42

210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	212,458,400.00	211,583,198.42
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	110,459,300.00	110,459,258.13
210101	Үндсэн цалин	76,036,800.00	74,629,875.93
210102	Нэмэгдэл	19,476,100.00	10,907,123.40
210103	Унаа хоолны хөнгөлөлт	13,200,000.00	15,496,000.00
210104	Урамшуулал	1,746,400.00	9,426,258.80
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	16,334,400.00	15,478,301.36
210201	Тэтгэврийн даатгал	9,515,000.00	11,000,791.79
210202	Тэтгэмжийн даатгал	1,704,800.00	1,119,447.44
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,363,900.00	895,557.90
210204	Ажилгүйдлийн даатгал	341,000.00	223,609.23
210205	Эрүүл мэндийн даатгал	3,409,700.00	2,238,895.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	5,660,100.00	5,658,687.39
210301	Гэрэл, цахилгаан	480,000.00	422,087.39
210302	Түлш, халаалт	4,232,100.00	4,263,600.00
210303	Цэвэр, бохир ус	948,000.00	973,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	9,729,300.00	9,728,416.54
210401	Бичиг хэрэг	2,969,000.00	2,944,833.00
210402	Тээвэр, шатахуун	2,620,000.00	2,620,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,269,000.00	2,285,620.54
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	214,500.00	205,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,656,800.00	1,672,963.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	37,530,000.00	37,529,450.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	22,030,000.00	22,030,000.00
210602	Тавилга	13,500,000.00	13,500,000.00
210604	Урсгал засвар	2,000,000.00	1,999,450.00
2107	Томилолт, зочны зардал	3,000,000.00	2,984,000.00
210702	Дотоод албан томилолт	3,000,000.00	2,984,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	12,671,900.00	12,671,900.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	11,171,900.00	11,171,900.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,500,000.00	1,500,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	17,073,400.00	17,073,185.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	9,013,400.00	9,013,185.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	8,060,000.00	8,060,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	386,000.00	386,000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	386,000.00	386,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	386,000.00	386,000.00

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	106,577,700.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	106,577,700.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	106,577,700.00
2104	Хангамж, бараа материалын зардал	25,215,000.00
210402	Тээвэр, шатахуун	14,465,000.00
210404	Ном, хэвлэл	10,750,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	12,999,900.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	5,329,900.00
210602	Тавилга	7,670,000.00
2107	Томилолт, зочны зардал	3,984,000.00
210702	Дотоод албан томилолт	3,984,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	30,950,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	30,950,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	33,428,800.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	33,428,800.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	106,577,700.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	106,577,700.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	32,427,700.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө, түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	18,000,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	56,150,000.00

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Сүхбаатар аймгийн Соёл, урлагийн газар эрхэм зорилгоо “Соёл, урлагийн үйлчилгээний чанар хүртээмжийг дээшлүүлэн, соёлын өвийн уламжлалыг өвлүүлэн дэлгэрүүлж, хэрэглээнд нэвтрүүлэн, соёлын бүтээлч үйлдвэрлэлийг хөгжүүлэх, бүх нийтийг соён гэгээрүүлэх замаар өрсөлдөх чадвартай бүтээлч байгууллага, уран бүтээлч, иргэдийг хөгжүүлж, орон нутгийн тогтвортой хөгжилд соёл урлагийн үйл ажиллагааны үнэ цэнийг нэмэгдүүлнэ.” гэж тодорхойлсон байна.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Сүхбаатар аймгийн Соёл, урлагийн газрын үйл ажиллагааны чиглэлийг Соёлын тухай хуульд дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Соёлын хууль тогтоомжийн дагуу соёл, урлагийг хөгжүүлэх, иргэний соёлын эрэлт хэрэгцээг хангахад чиглэсэн арга хэмжээг хэрэгжүүлэх;
- Соёлын байгууллагын үйл ажиллагааг зохицуулж, хууль тогтоомжид заасны дагуу төрөөс санхүүжүүлэх, тэдгээрт дэмжлэг, туслалцаа үзүүлэх, ажиллагсдын нийгмийн баталгааг хангах арга хэмжээг авах;
- Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт заасан соёлын зорилтыг хэрэгжүүлэх ажлыг соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагатай хамтран зохион байгуулах;
- Харьяалах нутаг дэвсгэрийн соёлын байгууллагын үйл ажиллагааг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангаж, хяналт тавих;
- Соёлын статистик мэдээлэл, соёлын байгууллагын тайланг нэгтгэн холбогдох байгууллагад хүргүүлэх.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Тодруулбал Төрийн хэмнэлтийн хууль 2022 онд батлагдаж, мөрдөгдсөн байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилтийн үр нөлөө дунд зэрэг байна.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Сүхбаатар аймгийн Соёл, урлагийн газрын 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Сүхбаатар аймгийн Соёл, урлагийн газрын 2022 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна. Соёлын сайдын 2022.01.11-ний өдрийн А/02 дугаар тушаалаар НББ-ийн Бодлогын баримт бичиг батлагдсан байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 49.1 сая төгрөгөөр буюу 232.7 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мян.төг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Авлага	15,000.0	0.0	-15,000.0
Бараа материал	4,403.9	11,870.4	7,466.5
Үндсэн хөрөнгө	1,661.0	58,275.4	56,614.4
Нийт хөрөнгө	21,064.9	70,145.8	49,080.9
Өр төлбөр	0.0	0.0	0.0
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	21,064.9	70,145.8	49,080.9
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	21,064.9	70,145.8	49,080.9

Дээрх хүснэгтээс харахад, өмнөх оны үзүүлэлтээс нөлөө бүхий өөрчлөлт гарсан үндсэн хөрөнгийн данс байна. Үндсэн хөрөнгийн данс өмнөх оноос 56.6 сая төгрөгөөр нэмэгдсэн нь дээд шатны байгууллагаас үнэ төлбөргүй болон төсвийн хөрөнгөөр хөрөнгө худалдан авсантай холбоотой байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллага нь 2021 оны 9 дүгээр сард байгуулагдсан тул 2022 оны төсвийн төсөл боловсруулагдаагүй бөгөөд 2022 оны төсөв 216.0 сая төгрөгөөр батлагдсан байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант оны батлагдсан төсвийг 3.2 сая төгрөгөөр бууруулж тодотгосон байна. Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 2 арга хэмжээг санхүүжүүлэхээр 212.8 сая төгрөгийг улсын төсвөөс бүрдүүлэхээр байна.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 212.8 сая төгрөгийн санхүүжилт олгосон байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 212.0 сая төгрөг буюу 99.6 хувьтай байгаа нь үндсэн үйл ажиллагааны зардлын төсвийг 0.8 сая төгрөгөөр дутуу зарцуулсантай холбоотой байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж 32.4 сая, ЗГНХ, ЗДНХөрөнгө, түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан 18.0 сая, дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө 56.2 сая нийт 106.6 сая төгрөг нэмэлт санхүүжилтийн дансаар орж, зарцуулагдсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Сүхбаатар аймгийн Соёл, урлагийн газрын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд шалгуур үзүүлэлтийн суурь ба хүрэх түвшнийг тодорхойлохдоо үйл ажиллагааны статистик тоон мэдээллийг бага ашигласан, үндсэн хөрөнгийн шинжтэй хөрөнгийг бараа материалын дансанд бүртгэсэн, цахим дэлгүүрээс зөөврийн болон суурин компьютерыг худалдан авалгүйгээр бусад этгээдээс худалдан авсан, цахим дэлгүүрт байхгүй арван сая төгрөгөөс дээш өртөг бүхий бараа, үйлчилгээг цахим дэлгүүрт байршуулах хүсэлт хүргүүлээгүй, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулахтай холбоотой шийдвэрийг шилэн дансны цахим хуудаст мэдээлээгүйтэй холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Сүхбаатар аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Э.Алтансүх гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Г.Даваа, газрын дарга, тэргүүлэх аудитор М.Нарантуяа нар тус тус хэрэгжүүлсэн.

Сүхбаатар аймгийн Соёл, урлагийн газрын 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Сүхбаатар аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 02/10 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2022 оны нийт зардлын 266.7 сая төгрөгөөс 1.0 хувиар буюу 2.7 сая төгрөгөөр, тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Тус байгууллага нь 2021 оны 9 дүгээр сард байгуулагдсан тул тайлант оны төсвийн гүйцэтгэлд өмнөх оноос буурсан зардал байхгүй байна. Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор тус байгууллагын харьяа байгууллагын албан хаагч нарт 2 удаа цахим сургалт хийсэн байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулахтай холбоотой 64.3 сая төгрөгийн 11 шийдвэрийг шилэн дансны цахим хуудаст мэдээлээгүй нь Шилэн дансны тухай хуулийн 6.4.8 дахь заалттай нийцэхгүй байна.

4.5 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Тус байгууллага нь 2021 оны 9 сард байгуулагдсан бөгөөд өмнөх онд аудитад хамрагдаагүй байна.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 1.3 сая төгрөгийн 1 алдаа¹ илэрсэн бөгөөд уг алдааг дараагийн тайлант хугацаанд залруулах зөвлөмж өглөө.

Аудитаар нийт 4 зөрчил² илэрсэн бөгөөд эдгээр зөрчлийг давтан гаргахгүй байх зөвлөмж өгсөн.

5.1 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөтэй холбоотой асуудал

Илрүүлэлт:

Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд шалгуур үзүүлэлтийн суурь ба хүрэх түвшнийг тодорхойлохдоо үйл ажиллагааны статистик тоон мэдээллийг бага ашигласан нь Засгийн газрын 2020 оны 217 дугаар тогтоолоор батлагдсан "Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулах, гүйцэтгэлийн зорилт, шалгуур үзүүлэлтийг тогтоох, тайлан гаргах журам"-ын 2.4.3 дахь "шалгуур үзүүлэлтийн хүрэх түвшин нь тухайн жилдээ хэрэгжих боломжтой, тоон ба чанарын утгаар илэрхийлэгдэх, хэмжигдэхүйц, үр дүнг харуулсан байх бөгөөд бодлогын баримт бичиг, статистик тоон мэдээлэл, салбарын мэдээлэлд үндэслэх, арга хэмжээний хүрэх түвшин нь зорилтын үр дүнг илэрхийлсэн байх" заалттай нийцэхгүй байна. Гүйцэтгэлийн төлөвлөгөөний шалгуур үзүүлэлтийг оновчтой тодорхойлоогүй нь төсвийн хөрөнгийн зарцуулалтын үр ашгийг бууруулах сөрөг үр дагавартай байна.

Өгсөн зөвлөмж:

Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд шалгуур үзүүлэлтийн суурь ба хүрэх түвшнийг тодорхойлохдоо үйл ажиллагааны статистик тоон мэдээллийг түлхүү ашиглах, мөн аймаг, орон нутгийн түвшинд соёл, урлагийн салбарын хөгжлийн шалгуур үзүүлэлтүүдийг тодорхойлж, гүйцэтгэлийн төлөвлөгөөний шалгуур үзүүлэлт болгон ашиглаж, төсвийн хөрөнгийн зарцуулалтын үр ашгийг нэмэгдүүлэх.

2. Үндсэн хөрөнгөтэй холбоотой асуудал

Илрүүлэлт:

Баримт үдэгч, суурин ус буцалгагч, сандал зэрэг үндсэн хөрөнгийн шинжтэй 0.3-0.4 сая төгрөгийн өртөгтэй, нийт 1.3 сая төгрөгийн хөрөнгийг бараа материалын дансанд бүртгэсэн байна. Энэ нь УСНББОУС 12-Бараа материал, нь УСНББОУС 17-Үндсэн хөрөнгө, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 4.1.3 дахь "Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт" заалттай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж:

УСНББОУС болон "Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг"-т заасан "Үндсэн хөрөнгө", "Бараа материал"-ын тодорхойлолтын дагуу үндсэн хөрөнгө, бараа материалыг ялгамжтай бүртгэх.

3. Цахим худалдан авалттай холбоотой асуудал

Илрүүлэлт:

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

Цахим дэлгүүрт байршсан зөөврийн болон суурин компьютерыг худалдан авалгүйгээр бусад этгээдээс 20.7 сая төгрөгөөр худалдан авсан нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 14.4 дэх "Цахим дэлгүүрт байршсан бараа, үйлчилгээг бусад этгээдээс худалдан авахыг хориглоно." заалттай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Цахим дэлгүүрт байгаа бараа, үйлчилгээг бусад этгээдээс худалдан авахгүй байх, Төрийн хэмнэлтийн хуулийг хэрэгжүүлж ажиллах.

4. Цахим худалдан авалттай холбоотой асуудал

Илрүүлэлт:

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 14.1-д "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд заасан захиалагч нь тухайн жилд худалдан авах 10 сая төгрөгөөс дээш өртөг бүхий бараа, үйлчилгээний жагсаалтыг цахим дэлгүүрт байршуулах хүсэлтийг өмнөх онд худалдан авсан тоо хэмжээ, нэгж үнийн хамт төрийн худалдан авах ажиллагааны асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад хүргүүлнэ." заасны дагуу хүсэлтийг холбогдох байгууллагад хүргүүлээгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Тухайн жилд худалдан авах 10 сая төгрөгөөс дээш өртөг бүхий бараа, үйлчилгээ цахим дэлгүүрт байхгүй тохиолдолд холбогдох бараа, үйлчилгээний жагсаалтыг цахим дэлгүүрт байршуулах хүсэлтийг өмнөх онд худалдан авсан тоо хэмжээ, нэгж үнийн хамт Төрийн худалдан авах ажиллагааны газарт хүргүүлж ажиллах.

5. Шилэн данстай холбоотой асуудал

Илрүүлэлт:

Төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулахтай холбоотой 64.3 сая төгрөгийн 11 шийдвэрийг шилэн дансны цахим хуудаст мэдээлээгүй нь Шилэн дансны тухай хуулийн 6.4.8 дахь заалттай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Шилэн дансны тухай хуулийн 6.4.8-д заасны төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулахтай холбоотой шийдвэрийг шилэн дансны нэгдсэн цахим хуудаст мэдээлж байх.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2023 оны 5 дугаар сарын 31 -ний өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Үндсэн хөрөнгийн шинжтэй хөрөнгийг бараа материал дансанд бүртгэсэн	1	1,296.0	-	-	1	1,296.0	-	-	1	1,296.0	1	1,296.0
Дүн	1	1,296.0	-	-	1	1,296.0	-	-	1	1,296.0	1	1,296.0

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил	Үүнээс				
		Төлбөрийн акт	Албан шаардлага	Зөвлөмж	Хариуцлага тооцуулах албан шаардлага	Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал

	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Гүйцэтгэлийн төлөвлөгөөнд шалгуур үзүүлэлтийг оновчгүй тодорхойлсон	-	-	-	-	-	-	1	-	-	-	-	-
Дүн	-	-	-	-	-	-	1	-	-	-	-	-

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		/мянган төгрөгөөр/					
			Үүнээс					
	Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулахтай холбоотой шийдвэр мэдээлээгүй	-	-	-	-	-	-	1	64,345.3
Дүн	-	-	-	-	-	-	1	-
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Цахим дэлгүүрт байгаа барааг бусад этгээдээс худалдан авсан	-	-	-	-	-	-	1	20,733.8
10 саяас дээш өртөг бүхий барааг цахим дэлгүүрт байршуулах хүсэлт хүргүүлээгүй	-	-	-	-	-	-	1	-
Дүн	-	-	-	-	-	-	2	-
Нийт дүн	-	-	-	-	-	-	3	85,079.1